



ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САНГИЙН ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖИЖ, ЗОРИЛТОД БҮЛЭГТ ЧИГЛЭГДЭН ҮР
ДҮНГЭЭ ӨГЧ БАЙГАА ХЭДИЙ Ч ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймгийн Аудитын
газрын II баг

Дарга, Тэргүүлэх аудитор

Х.Түвшинбаяр

Аудитын менежер

Д.Эрдэнэчимэг

Шинжээч

Э.Сүнжидмаа

Х.Билэгбаяр

2016 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70483413,
70484030 дугаарын утас,
70483413 дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум Баянхайрхан
баг, Аудитын газар

АГУУЛГА

Аудитын зорилт, арга зүй, стандартыг талаарх
мэдэгдэл.....
Аудитад ашигласан шалгуур.....
Товчилсон үгийн тайлбар.....
Ерөнхий мэдээлэл.....

**БҮЛЭГ-1 САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН
БАЙНА.**

**БҮЛЭГ-2 ОРОН НУТАГТ САНГИЙН ХӨРӨНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ ХИЙГДЭЭГҮЙ УЧРААС
2 ДУГААР БҮЛЭГТ ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ
БАЙНА.**

**БҮЛЭГ-3 МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САНГААС
САНХҮҮЖҮҮЛСЭН ТЭТГЭЛЭГИЙН ЗАРДЛЫГ
19,605.7 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ЗОРИУЛАЛТ
БУСААР ЗАРЦУУЛСАН ХЭДИЙ Ч ЗОРИЛТОТ
БҮЛЭГТ ЧИГЛЭГДЭН ҮР ДҮНГЭЭ ӨГЧ БАЙНА.**

**БҮЛЭГ-4 ОРОН НУТАГТ ДОТООД ХЯНАЛТЫН
ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ УЧРААС ХЯНАЛТ,
ШАЛГАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
МСҮТ	Мэргэжилийн сургалт үйлдэрлэлийн төв
МБСДС	Мэргэжлийн боловсролыг сургалтыг дэмжих сан
МУ	Монгол Улс
НА	Нийцлийн аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал

**АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ,
БҮРЭН ЭРХ**

АУДИТЫН ЗОРИЛТ

**АУДИТЫН ХАМАРСАН
ХҮРЭЭ**

**АУДИТЫН АРГА ЗҮЙ
СТАНДАРТЫН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ**

**АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, ХАМАРСАН
ХҮРЭЭ, БЭРХШЭЭЛ**

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 1 дүгээр тогтоол, УАГ-ын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газар хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Батлан хамгаалахын сайдын 2009 оны 290 дүгээр тушаалаар баталсан Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журмаар тодорхойлсон “Мэргэжлийн боловсрол сургалтын сан”, “Байгаль орчныг хамгаалах сан”, “Сургалтын төрийн сан”, Зэвсэгт хүчний хөгжлийн сангуудын үйл ажиллагаа, эдгээр сангаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд аудит хийж дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитад “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн сургалтын тэтгэлэгийн зардалд хамрагдсан Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулиудыг хамруулан шалгалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөр, Говь-Алтай аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, нотлох баримт материал судалгаа, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн дүгнэлт зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг **"ДУНД"** гэж үнэлэв.

АУДИТЫН СТАНДАРТЫН ТАЛААРХИ МЭДЭГДЭЛ

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоол
- БСШУС-ын 2006 оны 189 дүгээр тушаал "Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага /МСҮТ-колледж/-д суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам
- Мэргэжил боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам
- Дээрхи хуулийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт

АУДИТЫН ХУГАЦАА

Аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 01 нээс эхлэж 10 сарын 05-ны өдөр дуусгаж Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн стандартыг хангуулж, гүйцэтгэлийн багийн шинжээч Э.Сүнжидмаа, Х.Билэгбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдсэн.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говь-Алтай аймагт Байгаль орчныг хамгаалах сан, Сургалтын төрийн сан, Зэвсэгт хүчний сангууд байхгүй бөгөөд зөвхөн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тэтгэлэгийн зардал тус аудитад хамрагдсан болно.

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн хувьд:

Тус сургуульд 2015-2016 оны хичээлийн жилд нийт 928 оюутан суралцсанаас 143-147 суралцагчдад 9 мэргэжлээр дипломын боловсрол эзэмшүүлэн МБСДС-гаас ирцийн бүртгэлд үндсэлэн давхардсан тоогоор 1716 суралцагчдад 120,120.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгохоос 80,080.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгож 40,040.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгоогүй өглөгтэй байна. Баклаврын боловсролын 781 оюутнууд нь сурлагын дүнгийн голчоор БСШУЯ-аас 70.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгодог бөгөөд энэ нь аудитад хамрагдахгүй болно.

Аудитад хамрагдсан 2014-2016 онуудад “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-д 2 удаа өөрчлөлт орсон байна.

- Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралт “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь хэсэгт “Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй” гэж заасан байна. Гэвч давхардсан тоогоор 92 суралцагчдад 9,450.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг илүү тооцон олгосон 3 суралцагчдад 280.0 мянган төгрөгийг дутуу тооцон олгосон зөрчил илэрлээ.
- Мөн Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолын хавсралт “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам” –ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр /Эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт/ бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтанд 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх” гэж заасан хэдий ч 10 суралцагчдад 700.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг илүү тооцон олгосон зэрэг зөрчил илэрлээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хувьд:

Тус сургууль нь 2015-2016 оны хичээлийн жилд 210 суралцагчийг шинээр элсүүлэн нийт 578 суралцагчдыг 15 мэргэжлээр сурган ЕБС бүрэн дунд боловсролыг эзэмшүүлж байна. МБСДС-гаас 208,784.9 мянган төгрөгийг тэтгэлэгийг олгохоос 205,394.1 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгож 3,266.4 мянган төгрөгийг МБСДС-нд төвлөрүүлж 124.4 мянган төгрөгийг үлдэгдэлтэй байна. Анги удирдсан багш нар нь ирцын мэдээллээ нягтлан бодогчид гарган өгч нягтлан бодогч нь хичээл тасалсан цагийг заасан цагтай нь харьцуулан тэтгэлэгийг хувьчлаж олгож байгаа нь “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ыг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна. Аудитаар 53 ангийн давхардсан тоогоор 14880 суралцагчийн олгосон тэтгэлэг, журналын ирц түүн шалгахад 2015 онд 3,598.4 мянган төгрөгийг дутуу, 329.9 мянган төгрөгийг

суралцагчдад илүү тооцон олгосон, 2016 оны эхний хагас жилд 3,287.4 мянган төгрөгийн дутуу тооцон суралцагчдад олгосон зөрчил илэрлээ. МСҮТ-ийн 2012-2014 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар тэтгэлэгийн зарцуулалтыг тулган шалгаж цаашид алдааг давтахгүй байх талаар зөвлөмж өгч байсан хэдий ч алдаа дутагдал давтан гарсаар байгаа нь дотоод хяналт шалгалт муу хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ-1

Сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

➤ Хууль эрх зүйн зохицуулалт оновчтой байна?

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.1.1-д заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна. Үүнд: 6.2.6 мэргэжлийн боловсролын сургалтын сан” хэмээн заасны дагуу 2010 онд уг санг байгуулж Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолын хавсралт “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг батласан байна. Говь-Алтай аймагт тус сан байхгүй бөгөөд сангийн орлого бүрдүүлэлт хийгдээгүй.¹ Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдад олгосон тэтгэлгийн зардлын зарцуулалтыг аудитад хамруулан үзлээ.

Тус сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль², Боловсролын тухай хууль³, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль⁴, Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралт “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”⁵, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоол “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”⁶, Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолын хавсралт “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”⁷ болон салбарын бусад хууль тогтоомжуудаар эрх зүйн орчинг бүрэн тусгаж өгчээ.

¹ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21.1. “Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

² 6.2 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.1.1-д заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна. Үүнд: 6.2.6 мэргэжлийн боловсролын сургалтын сан”

³ 40.6. Дээд боловсролын сургалтын байгууллага болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно.

43.2.10. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу сар тутам тэтгэлэг олгох;

43.3. Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна.

⁴ 21.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

⁵ Өмчийн хэлбэр харгалзахгүй мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллага¹ (цаашид “сургууль” гэх)-д мэргэжлийн анхан, дунд шатны сургалтаар мэргэжил эзэмших 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоход энэхүү журмыг баримтална.

⁶ 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан (цаашид “Сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

⁷ Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага /цаашид/ сургалтын байгууллага гэх/ын суралцагчдад тэтгэлэг олгоход энэхүү журмыг баримтлана.

БҮЛЭГ-2: Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21.1. “Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу орон нутагт сангийн хөрөнгийн төлөвлөлт бүрдүүлэлт хийгдээгүй учраас 2 дугаар бүлэгт дүгнэлт өгөх боломжгүй байна.

БҮЛЭГ-3 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн тэтгэлэгийг зардлыг 19,605.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан хэдий ч зорилтод бүлэгтээ чиглэгдэн үр дүнгээ өгч байна.

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжиж байгаа боловч хяналт сул байгааг илтгэж байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг⁸, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дэхь хэсэг⁹, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгож журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дэхь хэсэг¹⁰, заасны дагуу сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн сургалтын тэтгэлэг нь хуулиар тодорхойлсон зорилттойгоо нийцэж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас Говь-Алтай аймагт 2015 онд 268,844.9 мянган төгрөг, 2016 онд 182,558.4 мянган төгрөг нийт 451,403.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуульд 80,080.0 мянган төгрөгийг, МСҮТ-д 371,323.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуульд 2015 онд МБСДС-гаас 29,190.0 мянган төгрөгийн сургалтын тэтгэлэг олгосныг 2015 оны 2-4 саруудад зарцуулсан бөгөөд үлдэгдэл 280.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж, төвлөрүүлээгүй байна. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1¹¹, 23.1.2¹², 23.1.3¹³, 23.1.4¹⁴, 23.1.5¹⁵-т заасны дагуу тогмтол зардал,

⁸ Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн үр чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино.

⁹ Сангийн хөрөнгөөр мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлнэ

¹⁰ Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтанд хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчид тэтгэлэг олгоно

¹¹ .төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал;

¹² өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт,

¹³ мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал;

түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал, нэг сурагчид ногдох хувьсах зардал, давтан сургалт, сургалтанд хамруулах зардал, сургалт зохион байгуулах зардлуудыг санхүүжүүлээгүй учраас зарцуулалт хийгдээгүй болно.

Хүснэгт №1

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн хувьд:

2015-2016 ОНЫ АШУУИС-ИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ САЛБАР СУРГУУЛИЙН ОРЛОГЫН СУДАЛГАА		
Орлогын төрөл	2015 он	2016 он
	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
Сургалтын төлбөрийн орлого	1,377,677.0	741,818.9
Оюутны байр банкны хүүгийн орлого	108,027.7	54,519.8
Тогтмол зардал/БСШУЯ/	85,670.9	
Сургалтын төрийн сан	74,263.0	5000.0
Сургалтын төрийн сан/замын зардал/	25,255.0	
Сургалтын тэтгэлэг /МБСДС/	29,190.0	
Нийт орлогын дүн	1,700,083.6	801,338.8

Тус сургууль нь МБС-ын асуудал эрхлэсэн төв захиргааны байгууллагаас 2013 онд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч сургалтын агуулга, төлөвлөгөө хөтөлбөрийг АШУУИС-д хүргүүлэн баталсан байна.

Мөн 2015-2016 оны хичээлийн жилд дипломын боловсрол эзэмших суралцагчдын элсэлтийн хяналтын тоог 210 хүүхдээр батлаж өгсөн бөгөөд сургуульд 85 суралцагчийг журмын¹⁶ дагуу элсүүлсэн байна. /Хавсралт №1/

Тус сургууль нь 2015-2016 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 1716 суралцагчдад 120,120.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 80,080.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг МБСДС-гаас санхүүжүүлэн ХААН болон Капитал банкаар дамжуулан олгож 40,040.0 мянган төгрөгийг олгоогүй өглөгтэй байна. Тус сургуулиас ирүүлсэн суралцагчдын тэтгэлэгийн жагсаалтыг банкнаас ирүүлсэн жагсаалтыг давтан тооцоолоход ямар нэгэн зөрүүгүй байна. /Хавсралт №2/

Аудитад хамрагдсан 2014-2016 онуудад “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-д 2 удаа өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4-т “Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй” гэж заасан боловч 2014-2016 онуудад давхардсан тоогоор 92 суралцагчдад 9,450.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг илүү тооцон олгосон, 3 суралцагчдад 280.0 мянган төгрөгийг журналын ирцээс дутуу тооцсон, мөн журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг зөрчин¹⁷ 3 суралцагчдад 24 нас хүрсэн байхад 1,050.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон байна. /Хавсралт №3/

¹⁴ хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах зардал;

¹⁵ үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах зардал.

¹⁶ БСШУС-ын 2006 оны 189 дүгээр тушаалын хавсралт//Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага/ МСҮТ, коллеж/-д суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам/

¹⁷ Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллага(Цаашид “сургууль” гэх)-д мэргэжлийн анхан дунд шатны сургалтаар мэргэжил эзэмших 24 нас хүртлэх суралцагчдад тэтгэлэг олгоно.

Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр /Эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт/ бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтанд 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх" гэж заасан хэдий ч ирц нь 75%-иас доош 10 суралцагчдад 700.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг илүү тооцон олгосон, уг журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг зөрчин¹⁸ 7 суралцагчдад 24 нас хүрсэн байхад 1,610.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон байна. /Хавсралт №4/

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хувьд:

МБС-гийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллагаас 2009 онд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 2015-2016 оны хичээлийн жилд элсэлтийн хяналтын тоог 420 суралцагчаар батлаж өгсөн бөгөөд 210 суралцагчдыг элсүүлсэн байна. Мэргэжлийн боловсролын сургалтын бодлогыг хэрэгжилт зохицуулах газраас сургалтын төлөвлөгөөг баталж ирүүлсэн байна. /Хавсралт №1/

Тус сургуулийн 2-3 дугаар ангийн 322 суралцагчдын хувийн хэргийг давтан тооцоолж үзэхэд БСШУС-ын 2006 оны 189 дүгээр тушаалын хавсралт "Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага /МСҮТ, коллеж/-д суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан суралцагчдыг элсүүлсэн бөгөөд ЕБС болон МСҮТ-д давхардан суралцдаг суралцагч байхгүй болно

Тэтгэлэгийн зардал:

2015 онд МСҮТ-ийн дансаар 208,784.9 мянган төгрөгөөр тэтгэлэгийн зардлыг санхүүжүүлснээс 14880 суралцагчдад 205,394.1 мянган төгрөгийг олгож, 3,266.4 мянган төгрөгийг МБСДС-д татан төвлөрүүлж, 124.4 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй үлдэгдэлтэй байна. /Хавсралт №5/

МСҮТ-өөс хүргүүлсэн ирцийн бүртгэлийг үндэслэн Хөдөлмөрийн яамнаас 10 дугаар сараас эхлэн сургалтын тэтгэлэгийг Хаан болон Капитал банкны дансаар дамжуулан олгосон байна. Банкны нэрийн жагсаалтанд орсон мөнгөн дүнг сургуулийн нэрсийн жагсаалттай тулгахад ямар нэгэн зөрүү гарсангүй.

Тус сургууль нь 2015-2016 онд Капитал банкаар дамжуулан нийт 162,538.4 мянган төгрөгийг олгожээ. 2015 онд 323,081.0 мянган төгрөгийг олгохоос 319,689.7 мянган төгрөг тэтгэлэгт олгож, 3,391.2 мянган төгрөгийн дутуу, 2016 оны эхний хагас жилд 131,309.8 сая төгрөг олгохоос 48,242.7 мянган төгрөгийг 83,067.1 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгоогүй өглөгтэй байна. Багшийн ирцийн бүртгэлийг нягтлан бодогчийн олгосон жагсаалттай тулгалт хийхэд 2015 онд 3,598.4 мянган төгрөгийг дутуу, 329.9 мянган төгрөгийг суралцагчдад илүү, 2016 оны эхний хагас жилд 3,287.4 мянган төгрөгийн дутуу тооцон суралцагчдад олгосон байна. /Хавсралт №6, 7, 7-1/

Тайлбар: Мэргэжлийн боловсролын сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнд асуудлын шинжилгээний 3.2, 3.3 дэх хэсэгт дүгнэлт өгөх боломжгүй болно.

3.4 Сургалтын тэтгэлэг нь зорилтот бүлэгтээ чиглэгдэн үр дүнгээ өгч байна.

МСҮТ-ийн сургалтын байр нь 450 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2015-2016 онд нийт 612 суралцагчтай хичээлийн жилийг эхлүүлсэн байна. Энэ нь суралцагчдад сургалтын тэтгэлэг олгодогтой холбоотой байна. Сургуулийн нийгмийн ажилтны

¹⁸ Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтанд хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоно.

судалгаагаар суралцагчдийн 17% нь амжиргааны түвшнээс доогуур орлоготой бөгөөд ар гэрийн амьдралд тэтгэлэгээс олгосон мөнгийг зарцуулдаг гэсэн тоон мэдээг гаргажээ.

Тус сургууль нь 2014-2015 оны хичээлийн жилийн сурлагын чанар 83.4% сургалтын амжилт 100%, ирцын дундаж 90 хувьтай байна. Харин 2015-2016 оны хичээлийн жилд сурлагын чанар 77.7% сургалтын амжилт 103%, ирцийн дундаж 85% болж буурчээ.

2016 оны 3-5 саруудад сургалтын тэтгэлэг олгоогүй нь дээрх үзүүлэлт буурахад нөлөөлөх шалтгаанд тооцогдож байна. Түүнчлэн хичээлийн жилийн сүүлээр суралцагчдын тоо 552 болж буурсан бөгөөд үүнээс 11 суралцагч сургуулиас жилийн чөлөө авсан, 2 суралцагч шилжсэн, үлдсэн 47 суралцагч сургууль завсардсан байна.

2016 онд МСҮТ-д 232 суралцагч төгссөнөөс 132 буюу 56% нь ажлын байраар бүрэн хангагдаж 36 суралцагч нь үргэлжлүүлэн мэрэгжил дээшлүүэн суралцаж байна.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн оюутны арга зүйч болон холбогдох албан тушаалтан нар сүүлийн жилүүдэд суралцагчдын сурлагын голч өсч байгаа, суралцагчдын идэвхи ирц сайжирсан, мөн суралцагч нь тэтгэлэгийн мөнгийг сургалтын төлбөртөө өгдөг гэсэн тайлбарыг хийлээ. Мөн АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь анагаах ухааны салбар сургуулийн дипломын ангийн төгсөгчдийн 88% нь ажлын байраар хангагдаж байгаагаас үзвэл сургалтын тэтгэлэг нь зорилтот бүлэгтээ хүрч үр дүнгээ өгч байна.

БҮЛЭГ-4

Орон нутагт дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй учраас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод хяналт хийгдэх тогтлолцоо бүрдээгүй байна.

Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолын хавсралт “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” -ын 4 дүгээр зүйлийн 4.3 дэхь хэсэгт¹⁹ зааснаар орон нутагт сангаас олгож байгаа хөрөнгөнд хяналт тавих боломжгүй бөгөөд Үндэсний зөвлөл, боловсрол, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг хийж өгсөн байна. Сургалтын байгууллага нь ирцийн мэдээллийг буруу гаргаж хүргүүлсэнээр МСҮТ нь 7,215.7 мянган төгрөг, АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны салбар сургуульд 9,450.0 мянган төгрөгийг илүү, дутуу олгосон байна.

Мөн 24 нас хүрсэн суралцагчдад 2,660.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас 2016 оны 1 дүгээр сараас эхлэн хасалтыг хийсэн хэдий ч хоногоор тооцоогүйгээс 7-11 сараар тэтгэлгийг илүү тооцон олгосон байна. Үүнээс үзэхэд орон нутагт дотоод хяналтын тогтолцоо хангалттай бүрдээгүй, мөн хяналт шалгалт хийгдээгүй байна.

¹⁹ Журмын хэрэгжилтэнд Үндэсний зөвлөл, боловсрол, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

Шилэн дансны хуулийн 5.5.5-д заасан, 6.4.4-д заасан мэдээлэлийг байршуулж байгаа хэдий ч МСҮТ нь 15,506.4 мянган төгрөгөөр тэтгэлэгийг дутуу мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дэхь хэсэг²⁰ болон 6 дугаар зүйлийн 6.4.4 хэсэгт²¹ заасны дагуу мэдээлэх үүрэгтэй.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хувьд МБСДС-гаас 2015 онд 208,784.9 мянган төгрөгийн сургалтын тэтгэлэгийн санхүүжилтанд зориулан олгогдсоноос 205,394.1 мянган төгрөгийг суралцагчдад олгосон байна. Тэтгэлэгийн орлого зарцуулалтыг www.shilendans.gov.mn сайтад бүрэн байршуулсан эсэхийг тулган үзэхэд 15,506.4 мянган төгрөгөөр тэтгэлэгийг зардлыг дутуу мэдээлсэн байна.

АШУҮИС-ын Говь-Алтай аймаг дахь салбар анагаах сургуулийн дансаар 2015 онд суралцагчдын тэтгэлэгт 29,190.0 мянган төгрөгийг олгосоноос шилэн дансанд хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна. *Хавсралт №8*

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

МСҮТ-ийн 2012-2014 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар сургалтын тэтгэлэгийн зардал, байрны хүүхдийн хоолны зардлыг тусгайлан авч үзсэн. Аудитаар тэтгэлэгийг илүү дутуу тооцон олгосон, МСҮТ-д суралцагчгүй хүүхэдэд тэтгэлэг олгосон, сургуулиас гарсан суралцагчдад тэтгэлэг олгосон зэрэг нийт 13,826.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон хэдий ч 2016 оны 09 дүгээр сарын байдлаар 5,758.4 мянган төгрөгийг тэтгэлэгийн актын үлдэгдэлийг барагдуулж ажиллаагүй байна. Аудитаар суралцагчдын тэтгэлэгийн олголтын зөрчил давтан гарч байгаа нь аудитын шийдвэрийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжүүлж ажиллаагүй байгааг харуулж байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,516.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэнээс МСҮТ-д 22,721.7 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 2 заалт бүхий албан шаардлага, МБСДС-гийн санд 124.0 мянган төгрөгийн тэтгэлэгийн үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуульд 12,390.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 заалттай албан шаардлага, хариуцлага тооцох 1 заалт бүхий албан шаардлага, МБСДС-гийн санд 280.0 мянган төгрөгийн тэтгэлэгийн үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Зөрчлийг задалвал:

1. АШУҮИС-ийн Говь-Алтай аймгийн анагаах ухааны салбар сургуулийн 2014-2016 оны хичээлийн жилд суралцсан дипломын ангийн 92 суралцагчдад 9,450.0 мянган төгрөгийг тэтгэлэгийг илүү тооцон олгосон, 3 суралцагчдад 280.0 мянган төгрөгийг тэтгэлэгийн журналын ирцээс дутуу тооцон олгосон. Мөн 24 нас хүрсэн 10 суралцагчдад 2,660.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон,
2. МСҮТ-ийн 2015-2016 оны тэтгэлэгийг тулгахад сурагчагчдад 329.9 мянган төгрөгийг тэтгэлэгийг илүү, 6,885.8 мянган төгрөгийн тэтгэлэгийг дутуу тооцон олгосон,

²⁰ 5.5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.

²¹ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

3. АШУҮИС Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуульд олгосон тэтгэлэгийн санхүүжилт 280.0 мянган төгрөг, МСҮТ нь 124.3 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг нийт 404.3 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,
4. МСҮТ нь 2015 онд шилэн дансанд байршуулах тэтгэлэгийн зардлыг 15,506.0 мянган төгрөгөөр дутуу байршуулсан зэрэг зөрчлүүд байна.

Аудитаас дараах шийдвэрийг хүргүүлж байна.

Албан шаардлага:

- **АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн захирал М.Банзаагаяад:**
 1. Сургалтын тэтгэлэгийг төвлөрүүлээгүй үлдэгдэл санхүүжилт 280.0 мянган төгрөгийг МБСДС-гийн дансанд төвлөрүүлэх
 2. Хариуцсан ажилдаа хайнга хандаж суралцагчдын ирцийн мэдээлэлийг буруу гаргаж төсөвт 12,390.0 мянган төгрөгийн хохирол учруулсан оюутны албаны арга зүйч С.Жамбалдоржид хуулийн дагуу хариуцлага тооцох
 3. Суралцагчдийн ирцийн мэдээллийг үнэн зөв тооцон гаргаж алдаа зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг сайжруулах

Төлбөрийн акт:

- **АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн захирал М.Банзаагаяад:**
 1. Сургалтын тэтгэлэгийг төвлөрүүлээгүй үлдэгдэл санхүүжилт 280.0 мянган төгрөгийг МБСДС-гийн дансанд төвлөрүүлэх

Албан шаардлага:

- **МСҮТ-ийн Захирал Д.Цоож**
 1. Суралцагчдийн ирцийн мэдээллийг үнэн зөв тооцон гаргаж алдаа зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг сайжруулах
 2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төлбөрийн акт

- **МСҮТ-ийн Захирал Д.Цоож**
 1. Сургалтын тэтгэлэгийг төвлөрүүлээгүй үлдэгдэл санхүүжилт 124.3 мянган төгрөгийг МБСДС-гийн дансанд төвлөрүүлэх

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫГ ДЭМЖИХ
САНГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ЗОХИХ ТҮВШИНД
ХЭРЭГЖИЖ, ЗОРИЛТОД БҮЛЭГТ ЧИГЛЭГДЭН ҮР ДҮНГЭЭ
ӨГЧ БАЙГАА ХЭДИЙ Ч ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.**



АШУУИС

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ
ДАХЬ АНАГААХ
УХААНЫ СУРГУУЛЬ

Харзат баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг
Утас: 70483491 Факс 70483491

2016.10.05 № 486
танай 2016.09.30 ны № 298

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Албан тоотын хариу хүргүүлэх
тухай.

Засгийн Газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Аудитаар гарсан алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрч байна.

Оюутнуудад олгосон Үндэсний тэтгэлгийн мөнгийг төлүүлэхээр тавьсан актын төлбөрийг эргүүлэн төлөх боломжгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Дипломын ангийн оюутнууд Сургалтын төрийн сангийн ямар нэгэн зээл тусламжид хамрагдах боломжгүй байдаг бөгөөд сургалтын төлбөрөө хувиараа төлж суралцдаг.
2. Орон нутгийн их дээд сургуульд амьжиргааны түвшин доогуур орлоготой ерхийн оюутнууд суралцдаг.
3. Тэтгэлгийн мөнгө нь арилжааны банкуудаар дамжин оюутнуудын дансанд ордог тул нөхөн суутгах боломжгүй байна.

Уг аудитаар гарсан алдаа, зөрчил дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

Иймээс та бүхэн дээрх оюутнуудаас тэтгэлгийг буцаан суутгах боломжгүй тул актнаас чөлөөлж өгөхийг хүсэж байна.

ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯ-БО



М.БАНЗААГАЯА

Д.ЭНХТҮВШИН

tom balank AUK

4300000150

Хөдөлмөрийн яамны харьяа
**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

82083 Жаргалант баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг
Утас/Факс: 70-48-37-16

2016.10.03. № 200

танай 2016.09.30 -ны № 298 -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Засгийн Газрын тусгай сан / МБСДС/-гийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан хүлээн зөвшөөрлөө.

Тайланд тусгагдсан төлбөр барагдуулах акт, зөрчил арилгуулах албан шаардлагуудыг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг хугацаанд хүргүүлэх болно.

ЗАХИРАЛ



Д.ЦООЖ

101390

№	АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн санал	Хариу тайлбар
1	Дипломын ангийн оюутнуудын сургалтын төрийн сангийн ямар нэгэн зээл тусламжинд хамрагдах боломжгүй сургалтын төлбөрөө хувиараа төлдөг.	Сургалтын тэтгэлэгийн зардал нь 2016 оны 2 сараас зогсоосон бөгөөд арилжааны банкаар дамжин суралцагчдын нэрийн дансанд ордог байна. Иймд хариуцагч байгууллагын саналыг хүлээн авч албан шаардлага болголоо.
2	Орон нутгийн дээд сургуульд амжиргааны түвшин доогуур орлоготой өрхийн оюутнууд суралцдаг.	
3	Тэтгэлэгийн мөнгө нь арилжааны банкуудаар дамжин оюутнуудын дансанд ордог тул нөхөн суутгах боломжгүй юм.	